

ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.03.24

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Богд Банк хк монголын хөрөнгийн биржийн бүртгэлээс хасагдлаа
- ТОП-20 индекст Инновейшн Инвестмент ХК нэмэгдлээ
- Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн эдийн засгийн төсөөлөл

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	0.82%	2.05%	25.47%
MSE A	-1.86%	1.95%	20.27%
MSE B	-2.32%	3.99%	34.89%

2025/03/17 – 2025/03/21

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
XAC	1,534,394,502.91
INV	522,129,065.00
KHAN	429,218,963.00
MSE	229,575,719.71
ERDN	177,943,170.00

2025/03/17 – 2025/03/21

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
MBG	14.50	16.00%
MVO	1,265.00	15.00%
TAND	23.00	15.00%
AMT	8.70	8.34%
TUM	389.77	4.86%

2025/03/17 – 2025/03/21

2025 он 03-р сарын 24

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

12,968

ТОП-20 индекс

51,635

MSE A

19,723

MSE B

14,711



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

4.9%

2024 он

Инфляц

9.6%

2025-02 сар

ГВУН(сая\$)

4,763.40

2025-02 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.92%

USD/MNT

3,476.98

2025-03-23



Эдийн засгийн мэдээлэл


ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН 2026-2028 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ



Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2026-2028 оны эдийн засгийн төсөөлийг хураангуйлан хүргэе.

Голлох үзүүлэлтүүд

Бодит ДНБ өсөлтийн төсөөлөл



Эдийн засгийн өсөлт:

- 2026-2028 онд 5.4-5.7% байх төлөвтэй
- Огцом өсөлт гарахгүй, харин тогтвортой, хязгаарлагдмал өсөлт үргэлжилнэ

Бодит инфляцийн төсөөлөл



Инфляцийн хандлага:

- 2026 онд 8.2%, 2027 онд 7.2%, 2028 онд 6.8%
- Төсөөллөөс үзвэл инфляц аажмаар буурах боловч эдийн засагт тодорхой дарамт үзүүлсээр байх магадлалтай

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын дараах эдийн засгийн уналт болон сэргэлтийн мөчлөг 2025 онд дуусах бөгөөд 2026-2028 онд эдийн засаг халалттай байх төлөв ажиглагдаж байна. Тус хугацаанд эдийн засгийн өсөлт харьцангуй өндөр буюу 6% орчим байхаар төсөөлөгджээ.

Эдийн засгийн өсөлтийг тэтгэгч гол хүчин зүйл нь экспорт, өрхийн хэрэглээ, төсвийн хөрөнгө оруулалт байх бол хувийн секторын хөрөнгө оруулалт өсөлтөд нейтраль, импортод сөрөг нөлөө үзүүлнэ.

Инфляц 2025 онд засгийн газраас авч хэрэгжүүлэх, алдагдал бууруулах чиглэлд авах зарим арга хэмжээнээс үүдэн өсөх бол цаашид зорилтот түвшний нөлөөгөөр буурах төлөвтэй байна.



Дотоодын зах зээлийн мэдээлэл

БОГД БАНК ХК МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАГДЛАА



"Монголын хөрөнгийн бирж" ХК нь "Богд Банк" ХК-ийн 80 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 1.25 тэрбум ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасах шийдвэр гаргалаа.

Энэхүү шийдвэр нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Монголын хөрөнгийн биржийн дүрэм, Үнэт цаасны бүртгэлийн журам болон "Богд Банк" ХК-аас ирүүлсэн 2025 оны 2-р сарын 10-ны өдрийн 554 тоот, 3-р сарын 10-ны өдрийн 737 тоот хүсэлтэд үндэслэн Бүртгэлийн хорооноос 2025 оны 3-р сарын 17-ны өдөр гаргасан шийдвэрийн дагуу хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн үзүүлэлтүүдээс дурдвал:

Тус банк нь өнгөрсөн 2024 онд татварын дараах цэвэр ашгаа өмнөх онтой харьцуулахад 42.4 хувиар нэмэгдүүлж, 40.1 тэрбум төгрөгт хүргэсэн билээ. 2024 онд банкны өөрийн хөрөнгийн өгөөж 26 хувьтай гарч, нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг 32.13 төгрөгт хүрсэн нь санхүүгийн үр ашиг нэмэгдсэнийг илтгэж байсан юм.



ТОП-20 ИНДЕКСТ ИННОВЕЙШН ИНВЕСТМЕНТ ХК НЭМЭГДЛЭЭ

Тэгвэл Монголын хөрөнгийн бирж ХК-ийн үнэт цаасны бүртгэлээс Богд банк ХК хасагдаж, оронд нь Инновейшн инвестмент ХК нэгдлээ.

Шинэ компанийн оролцоо ямар үр нөлөөтэй вэ?

Хөрөнгө оруулалт, технологийн Инновейшн инвестмент ХК нь ТОП-20 индексэд нэгдсэнээр зах зээл дэх нөлөөгөө улам бэхжүүлэх боломжтой. Энэ нь хөрөнгө оруулагчдад шинэ боломж нээж, зах зээлийн чиг хандлагад эерэг өөрчлөлт авчирч болзошгүй юм.

Хөрөнгө оруулагчдад энэ ямар ач холбогдолтой вэ?


ТОП-20 индекс нь Монголын хөрөнгийн зах зээлийг тодорхойлдог гол үзүүлэлт тул бүрэлдэхүүн өөрчлөгдөх нь зах зээлд шууд нөлөөлдөг. Шинээр багтсан компаниудын хөрвөх чадвар, арилжааны идэвх нэмэгддэг тул Инновейшн инвестмент ХК-д хөрөнгө оруулалт хийх сонирхол өсөх магадлалтай.

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2020)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Компанийн нэр	Симбол	Бүртгэх өдөр	Нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ
1	Дархан нэхий ХК	NEH	2025-03-10	0.226
2	Багануур ХК	BAN		23.62
3	Барилга корпораци ХК	BRC	2025-03-11	100
4	Хас Банк	XAC		27
5	Төрийн Банк ХК	SBM		63.70
6	Хаан банк ХК	KHAN		195.35
7	Материалимпекс ХК	MIE		150
8	Инвескор ББСБ ХК	INV		60
9	Айтүүлс ХК	ITLS		3.5
10	Мандал Даатгал ХК	MNDL		8.10
11	Улаанбаатар хивс ХК	UBH	2025-03-15	2000
12	Голомт Банк ХК	GLMT	2025-03-22	100
13	Сүү ХК	SUU		3.43
14	Таван толгой ХК	TTL		6960
15	Эм Жи Эл Акуа ХК	MGLA	2025-02-25	7.31
16	Гутал ХК	GTL	2025-03-31	2470
17	АПУ ХК	APU		65
18	Инновэйшн инвестмент ХК	QPAY		20
19	Монложистикс Холдинг ХК	MLG		5.4
20	Талх чихэр ХК	TCK		450
21	Би ди сек ХК	BDS		89.67
22	Сэндли ББСБ ХК	SEND	2025-03-15	7.61
23	Монгол Базальт ХК	MBW		2.42
24	Баянгол зочид буудал ХК	BNG		330
25	Тэнгэр Даатгал ХК	TGI		67.12
26	Монос хүнс ХК	MFC	2025-03-12	4
27	Газар Шим Үйлдвэр ХК	GAZR	2025-03-10	2.6
28	Улаанбаатар БУК ХК	BUK		10
29	Хүрд ХК	HRD		8
30	Тандэм инвэст ББСБ ХК	TAND		1.1
31	Бодь Даатгал ХК	BODI		5
32	Махимпекс ХК	MMX		100
33	Монгол шуудан ХК	MNP		1
34	Монголын хөрөнгийн бирж ХК	MSE		47
35	Гермес центр ХК	HRM	2025-03-07	9.60
36	ЛэндМН ББСБ ХК	LEND	2025-02-26	15
37	Эрдэнэт Суврага ХК	SVR	2025-02-26	5

T+2 төлбөрийн тооцооны системийн дагуу явдаг учир бүртгэлийн өдрөөс 2 өдрийн өмнөх эзэмшлээс тооцдог болохы анхаарна уу